



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/286

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил (Бугат, Орхон, Хангал, Хутаг-Өндөр 18608 га)"-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 2 дугаар багц "Орхон, Бугат сумдад 6300 га талбай"-н ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Грандфорест" ХХК-тай 170,269,110 (нэг зуун далан сая хоёр зуун жаран есөн мянга нэг зуун арав) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Грандфорест" ХХК-ийн захирал (Б.Жавхлантагс)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ГҮРЭВ-ОЧИР



6326010390

Сугд Ажил 2026 өдөр бүр

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20 ны/ний өдрийн
А/286 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)
3	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс)

--о00о--

Аймгийн Засаг даргын 2024. оны
 04 дүгээр сарын 20-ны/ний өдрийн
 А/286 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Ойн инженер (ерөнхий инженер)-1	Л.Уранбилэг	А.Гантөмөр
2	Шавьж судлаач, биологич-1	Г.Уранбилэг	
3	Ой зүйч	Б.Жавхлантагс	
4	Ой зүйч	Д.Урантогос	
5	Ой зүйч	Б.Цэрэндаваа	
Машин механизмын жагсаалт			
д/д	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Тэмцлийн ажилд шаардагдах ус зөөвөрлөх ажилд ашиглах бага дунд оврын ачааны автомашин-1	8275 УБМ	А.Гантөмөр
2	Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд шаардагдах шатах тослох материалуудыг зөөвөрлөх бага, дунд оврын автомашин-1	9082 УНМ	
3	Тэмцлийн ажилд ажиллах үйлчилгээний автомашин-1	0350 УЕА	
4	Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд дуслын хэмжээ нь 400 нанометрээс доошгүй байж мананцар үүсгэн шүрших хүчин чадалтай шүршигч тоног төхөөрөмж-10	12 ширхэг	
5	Агаарын хөлөг, дрон түүнтэй дүйцэхүйц тоног төхөөрөмж-1	DJI Agras T 50 дрон	

--o00o--